



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 07 дугаар
сарын 29 өдөр

Дугаар 6-16.

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Нэг. Улаанбаатар импэкс" компаний дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг тус компаний захирал/Б.Шаравсамбуу/ даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

 Ж.НАРАНЦАЦРАЛГ

Нийслэлийн засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагчийн
1998 оны 5-р сарын 16-ны өдөр захирамжийн
хавсралт

"УЛААНБААТАР ИМПЭКС" (УУГ) КОМПАНИЙ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 "Улаанбаатаримпэкс" компани нь (цаашид компани гэх) гадаад, дотоод худалдаа эрхэлж, Улаанбаатар хотын хүн ам, төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хүнс, өргөн хэрэглээний бараагаар хангах, хотын аюулгүйн нөөцийг бүрдүүлэн хадгалах , хадгаламжийн аж ахуй, жижиг үйлдвэрлэл эрхлэх зорилго бүхий нийслэлийн захирагчийн албаны хэрэгжүүлэгч агентлагийн чиглэлээр ажиллах төрийн өмчийн улсын үйлдвэрийн газар мөн.

1.2 Компани нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн Хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, нөхөрлөл компаний тухай хууль, иргэний хуульд тодорхойлсон төрийн болон орон нутгийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаа болон бусад хууль, тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3 Компани нь Нөхөрлөл, компаний тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу өөрийгөө удирдах, өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшин ашиглаж өөрийгөө санхүүжүүлэх зарчим дээр ажиллана. Компанийн хөрөнгө нь төрөөс эзэмшүүлсэн хөрөнгө, санхүүгийн нөөцөөс бүрдэнэ. Компани нь хөрөнгөө Монгол улсын хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах бөгөөд бие даасан тайлан тэнцэл гаргаж, банкинд дотоод , гадаад гүйлгээний харилцах данстай байна.

1.4 Компани нь өөрийн таних тэмдэгтэй байх бөгөөд зохих журмаар хийлгэсэн тэмдэг, тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Компанийг Нийслэлийн засаг даргын томилсон захирал удирдана. Компани нь Улаанбаатар хотын ерөнхий менежерийн эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Компанийг нийслэлийн засаг даргын шийдвэрээр өөрчлөх буюу татан буулгана.

Хоёр. Компанийн эрх, үүрэг

2.1 Компани нь дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ.

- а. Нийслэл хотын хүн ам, төсөвт байгууллагуудын эрэлт хэрэгцээг байнга тогтмол судалж гэрээ хэлцлийн үндсэн дээр гадаад дотоодын үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчээс гол нэрийн хүнс, өргөн хэрэглээний барааг авч худалдаалах.
- б. Экспортын үйл ажиллагаа явуулах, ялангуяа түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэж боловсруулан экспортлох.
- в. Агуулахын хадгалалтын аж ахуй хөгжүүлэх, гаалийн баталгаат агуулах ажиллуулах.

г. Төвлөрсөн журмаар зээл, тусламж, захиалгаар нийлүүлэгдсэн бараа материалыг зохих хуваарь чиглэлийн дагуу хэрэглэгчдэд хүргэх, бөөнөөр худалдаалах ажлыг завсарын шат дамжлагагүйгээр зохион байгуулах,

д. Улаанбаатар хотын аюулгүйн нөөцийн барааг бүрдүүлж хадгалах.

е. Жижиг үйлдвэрлэл эрхлэх, туслах аж ахуй хөгжүүлэх.

ё. Зах зээл дэх барааны хангамж, шинэ нэрийн бараа, дотоод гадаад зах зээлийн байдлын талаар мэдээлэл цуглуулж, гадаадын байгууллагатай хамтарч ажиллахад нь өмчийн бүх хэвшлийн худалдаа, нийтийн хоолны газар, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд тусалцаа үзүүлж, тэдгээрийн хооронд зуучлах.

ж. Улаанбаатар хотын хот нийтийн аж ахуйн хэрэгцээт болон тохижилттой холбогдох материалыг захиалгын үндсэн дээр бэлтгэж нийлүүлэх.

з. Компаныхаа үйл ажиллагаатай холбоотой бусад ажил, асуудлыг зохион байгуулж гүйцэтгэх.

2.2 Компани нь дор дурьдсан эрх эдэлнэ. Үүнд:

а. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу аж ахуйн болон гадаад эдийн засгийн үйл ажиллагааг бие даан явуулах.

б. Өөрийн бүрэлдэхүүнд аж ахуйн дотоод тооцооны үндсэн дээр жижиг үйлдвэр, агуулах, жижиглэнгийн цэг салбар ажиллуулах, түүнчлэн гадаад орон, бусад аймаг хоттой хамтарсан үйлдвэр, аж ахуйн газар байгуулах, гадаад болон дотоодод өөрийн төлөөлөгчийг явуулах.

в. Улсын стандарт, техникийн нөхцөл, чанар, үнэ, гэрээний шаардлага хангаагүй, хэрэглэгчийн эрх ашигт тохироогүй бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, худалдаалах, үнийг төлөхөөс татгалзах.

г. Хэрэглэгчийн болон компанийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон асуудлыг зохих шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

д. Компанийн аж ахуйн үйл ажиллагааны үр дүнтэй холбож орон тоо, ажилтан ажилчдын цалин, шагнал урамшууллын хэмжээг хамт олны саналыг үндэслэн тогтоож байх.

Гурав. Компанийн удирдлага

3.1 Компанийг Нийслэлийн засаг даргын томилсон захирал удирдаж компаний зорилго, үүргийг хэрэгжүүлж нийслэлийн засаг даргын тамгын газар, ерөнхий менежерт ажлаа тайлагнана.

3.2 Компанийн захирал нь Монгол улсын хууль тогтоомжинд нийцүүлэн өөрийн эрх мэдлийн хүрээнд тушаал гаргаж, биелэлтийг зохион байгуулна.

3.3 Захирал нь дор дурьдсан эрх эдэлнэ.

- а. Тухайн компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох.
- б. Компанийн нэрийн өмнөөс эд хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчийн хууль, Нийслэлийн өмчийн газартай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.
- в. Компанийн бизнес, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж зохих байгууллагаар хянуулан баталж, биелэлтийг хангах.
- г. Компанийн удирдлага зохион байгуулалтын бүтцийг тогтоож, албан тушаалтан, ажилчдыг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч, сангийн хэмжээнд багтаан цалин, урамшуулал тогтоох.
- д. Компанийн үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох.
- е. Эрх хэмжээнийхээ асуудлаар холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх заавар, журам гаргах.

3.4 Захирал нь дор дурьдсан үүрэг хүлээнэ.

- а. Тогтоосон журмын дагуу анхан шатны болон ня-бо бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан-тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах.
- б. Хөдөлмөрийн хууль тогтоомжинд нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх.
- в. Маргаантай асуудлаар компанийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах.

3.5 Компанийн гүйцэтгэх захирал ажлын аппараттай байхын зэрэгцээ асуудлыг шуурхай шийдвэрлэхэд зөвлөх үүрэгтэй захирлын зөвлөлтэй байна. Энэхүү зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирал тогтооно.

3.6 Компанийн захирал дараах үндэслэлээр ажлаас чөлөөлөгдөнө.

- а. Захирал хууль, тогтоомж зөрчсөн.
- б. Захирал өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй шалтгаан, нөхцөл бий болсон.
- в. Компанийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, дампуурсан.
- г. Хуульд заасан бусад үндэслэлүүд.